



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/363

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
ажлын байрны байршил
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3.1, 19.17, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2 дугаар хэсгийн 2.6.2, 6 дугаар хэсгийн 6.3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Хэрлэн сумын 1 дүгээр багийн Ж-36 дугаар байранд үйл ажиллагаа явуулж буй “Хэнтий Хэрлэн” ХХК-ийн Байгаль эмийн сангийн ажлын байрны байршлыг Хэрлэн сумын 3 дугаар багийн Өгөөж төвд шилжүүлэх хүсэлтийг зөвшөөрсүгэй.

3. Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн “Монжура” ХХК-ийн эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлгийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2022 оны 7 дугаар сарын 01-ээс эхлэн нэг жилийн хугацаатай шинээр олгосугай.

4. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

• 231010798

Аймгийн Засаг даргын 2022
онь... дугаар сарын...-ны
...захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
явуулах тусгай зөвшөөрлийг сунгасан байгууллагуудын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Галшар сумын "Хамба арц тун" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022.06.30- 2024.06.30
2	Биндэр сумын "Өсөн өрнөх" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022.06.27- 2024.06.27
3	Цэнхэрмандал сумын "Хаан дом" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022.07.06- 2024.07.06
4	Хэрлэн сумын "Хайрхан тун" ХХК-ийн эм ханган нийлүүлэх байгууллага	2 жил	2022.08.05- 2024.08.05
5	Хэрлэн сумын "Мөнхийн тунсаг" ХХК-ийн дотор, бөөр, хор судлалын үүдэн эмнэлэг	1 жил	2022.06.30- 2023.06.30